



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.1, 15.1.2, 16.1.2 дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн бусад байгууллагыг гадаад бодлогын асуудлаарх мэдээллээр хангах тухай журмыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн бусад байгууллагыг гадаад бодлогын асуудлаарх мэдээллээр хангах журмыг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох газар, нэгжүүдийн удирдлагад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гадаад хэргийн сайдын 2015 оны А/22 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ПҮРЭВСҮРЭН

Гадаад хэргийн сайдын 2015 оны
9 дугаар сарын 2-ны өдрийн
17/76 тоот тушаалын хавсралт



ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГЫГ ГАДААД БОДЛОГЫН АСУУДЛААРХ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1 Энэхүү журам нь төрийн бусад байгууллагыг Монгол Улсын гадаад бодлогын асуудлаарх мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, зохицуулах зорилготой.
- 1.2 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 266 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын хавсралтын 3.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2014 оны 06 тоот тогтоолын 2.1 дэх заалт зэргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг энэхүү журмаар мөн зохицуулна.

Хоёр. Мэдээллийн ангилал

- 2.1 Төрийн бусад байгууллагад хүргүүлэх мэдээлэл шуурхай мэдээ, танилцуулга, танилцуулах мэдээ, тойм мэдээ гэсэн ангилалтай байна.
 - 2.1.1 "шуурхай мэдээ" гэж тухайн үед болсон үйл явдал, хэргийн өрнөлийн талаархи мэдээллийг,
 - 2.1.2 "танилцуулга" гэж үйл явдал, асуудлын товч танилцуулга, тодорхой санал бүхий мэдээллийг,
 - 2.1.3 "танилцуулах мэдээ" гэж үйл явдал, асуудлын товч танилцуулга, явц, өрнөлтөд өгсөн үнэлэлт дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг тусгасан мэдээллийг,
 - 2.1.4 "тойм мэдээ" гэж тодорхой хугацаа / долоо хоног/ -нд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх гэж байгаа ажлыг тоймлосон мэдээллийг тус тус хэлнэ.

Гурав. Мэдээллийн эх сурвалж

3.1 Мэдээллийг дараах эх сурвалжаас авч болно. Үүнд:

- 3.1.1 Хилийн чанад дахь ДТГ-уудаас ирүүлсэн мэдээлэл / шуурхай мэдээ, танилцуулга, танилцуулах мэдээ/,
- 3.1.2 Дотоод болон гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэдээ,
- 3.1.3 Айлчлал, арга хэмжээний үеэр авсан мэдээлэл,
- 3.1.4 Яамны газар, нэгжээс авсан мэдээлэл,
- 3.1.5 Улаанбаатар дахь ДТГ-уудаас авсан мэдээлэл,
- 3.1.6 Төрийн болон төрийн бус байгууллагуудаас авсан мэдээлэл,
- 3.1.7 Бусад /албан бус, хувийн хэлхээ холбооны шугамаар авсан мэдээлэл/ зэрэг болно.

Дөрөв. Мэдээллийг боловсруулах

4.1 Яамны холбогдох газар нэгжүүд энэхүү журмын хавсралтаар тодорхойлсон хуваарийн дагуу мэдээллийг боловсруулах, чингэхдээ мэдээллийн эх сурвалжийг хянаж, бодлогын болон мэдээллийн чанараар ангилан ач холбогдлыг тогтооно.

4.2 Газар, нэгжүүд мэдээллийг цогц байдлаар эцэслэн боловсруулна.

Тав. Мэдээллийг түгээх

5.1 Мэдээллийг боловсруулахдаа Хувь хүний нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиудаар зохицуулсан мэдээллийг нууцлах, хамгаалах журмыг мөрдөнө.

5.2 Түгээх мэдээллийн агуулгаас хамаарч мэдээллийг нууцлах эсэхийг газар нэгжийн удирдлагууд зөвшилцөн шийдвэрлэнэ.

5.3 Эцсийн байдлаар боловсруулж нууцлах эсэхийг шийдвэрлэсэн мэдээллийг Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газарт түлхүүр үгээр нууцлан цахим шуудангаар хүргүүлэх бөгөөд тус газар нууцлах шаардлагагүй мэдээллийг албаны цахим шуудангаар, нууцлах шаардлагатай мэдээллийн албан бичгээр төр, засгийн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

5.4 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 266 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хавсралтын 3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 5.4.1, 5.4.2, 5.4.3-т заасан газар нэгжүүд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд шууд, бусад газар нэгжүүд дор дурдсан асуудлаар мэдээлэл бэлтгэж заасан хугацаанаас 72 цагийн өмнө Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар хүргүүлэх бөгөөд тус газар хянаж эцэслэн Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлнэ.

5.4.1 Монгол Улсын олон улсын гэрээнд нэгдэн орсон тухай танилцуулгыг Олон улсын эрх зүйн газар тухай бүр,

5.4.2 Монгол Улсын иргэн гадаадад гэмт халдлагын улмаас нас барсан, олон улсын болон олон улсын шинжтэй гэмт хэргийн хохирогч болсон, сураггүй алга болсон тухай шуурхай мэдээг Консулын газар тухай бүр,

5.4.3 Гадаадад байгаа манай иргэдийн үйлдсэн гэмт хэрэг, шүүхээр шийдвэрлэсэн болон ял эдэлж байгаа тухай танилцуулгыг Консулын газар 6,12 дугаар сарын 15-ны дотор,

5.4.4 Хөрш орнуудын дотоодод болж буй онцлог үйл явдал, гадаад бодлого болон манай улсын талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа, тэдгээрт гарсан өөрчлөлт, цаашдын хандлагын тухай танилцуулах мэдээг Хөрш орнуудын газар 3, 6, 9, 12 дугаар сарын 15-ны дотор,

5.4.5 Дэлхийн улс төрийн бодлогыг тодорхойлогч, манай “гуравдагч хөрш” орнуудын дотоодод болж буй онцлог үйл явдал, гадаад бодлого болон манай улсын талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа, тэдгээрт гарсан өөрчлөлт, цаашдын хандлагын тухай танилцуулах мэдээг Европ, Америкийн газар, Ази, ойрхи дорнод, африкийн газар тус бүр 3, 6, 9, 12 дугаар сарын 15-ны дотор,

5.4.6 НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд болж буй,

манай улсын эрх ашигтай холбоотой онцлог үйл явдлын тухай танилцуулах мэдээг Олон талт хамтын ажиллагааны газар 6, 12 дугаар сарын 15-ны дотор,

5.4.7 Гадаад бодлого, олон талт хамтын ажиллагааны хүрээнд манай баримтлах байр суурь өөрчлөгдсөн болон олон улс, бүс нутгийн тулгамдсан асуудлаарх манай байр суурийн тухай танилцуулгыг Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар тухай бүр,

5.4.8 Олон улсын эдийн засгийн харилцаа, дэлхийн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн чиг хандлага, тэдгээрийн манай улсын эдийн засагт үзүүлэх нөлөөний тухай танилцуулах мэдээг Эдийн засгийн хамтын ажиллагааны газар жил бүрийн 6, 12 дугаар сарын 15-ны дотор

5.5 Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2014 оны 06 тоот тогтоолын 2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын гишүүдэд Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны талаарх тойм мэдээг Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар сар бүрийн 5-ны дотор хүргүүлнэ.

5.6 Монгол Улсын Их Хурлын хавар, намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг үндэслэн гаргасан сэдвүүдийг Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар 2 болон 7 дугаар сард ДТГ-уудад мэдээлнэ. ДТГ-ууд дээрх сэдвүүдээр суугаа болон хавсран суугаа орнуудынхаа сайн туршлагын талаар сэдэвчилсэн танилцуулах мэдээг бэлтгэн 3 дугаар сарын 15 болон 9 дүгээр сарын 15-ны дотор төвд ирүүлнэ. ДТГ-уудаас ирүүлсэн танилцуулах мэдээг Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар Улсын Их Хурлын гишүүдэд хавар, намрын чуулганы өмнө хүргүүлнэ.

5.7 Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүдэд 5.4-т заасан мэдээллийг, Улсын Их Хурлын гишүүдэд 5.4.4 болон 5.4.5-д заасан мэдээллүүдийг дурдсан хугацаанд тус тус давхар хүргүүлнэ.

5.8 Монгол Улсын Засгийн газрын гишүүдэд 5.4, 5.5, 5.6-д заасан мэдээллийг тус тус дурдсан хугацаанд давхар хүргүүлнэ.

5.9 Аймгуудын удирдлагад 5.5-д заасан мэдээллийг дурдсан хугацаанд давхар хүргүүлнэ.

Зургаа. Мэдээллийн түгээлтийн хяналт

6.1 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал болон Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн мэдээллийн хувийг Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газарт хүргүүлнэ.

6.2 Энэхүү журмын хэрэгжилтэд Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар хяналт тавина.

Долоо. Хариуцлага

7.1 Мэдээллийн ач холбогдол, шуурхай байдлыг холбогдох газар, нэгжийн удирдлага шууд хариуцна.

7.2 Журамд заасан мэдээллээр төрийн байгууллагыг шаардлагатай дурдсан хугацаанд хангах ажлыг биелүүлээгүй, хяналт тавьж ажиллаагүй албан хаагч, удирдлагад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулна.